



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/409

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 66 дугаар дүгнэлтийн дагуу Эрүүл мэндийн салбарын их засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай/ ажлын 1 дүгээр багц Эрүүл мэндийн төвийн амбулаторийн их засвар /Өвөрхангай, Богд сум/ ажлыг 29988278 (хорин есөн сая есөн зуун наян найман мянга хоёр зуун далан найм) төгрөгөөр Дуутын нуруу ХХК-иар, 2 дугаар багц Эрүүл мэндийн төвийн дээврийн засвар /Өвөрхангай, Өлзийт сум/ ажлыг 13965147 (арван гурван сая есөн зуун жаран таван мянга нэг зуун дөчин долоо) төгрөгөөр Ганцаг ХХК-иар, 3 дугаар багц Сумдын Эрүүл мэндийн төвийг эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг 329890000 (гурван зуун хорин есөн сая найман зуун ерэн мянга) төгрөгөөр Нугантрейд ХХК-иар, 5 дугаар багц Багийн эмч нарыг компьютер, унаагаар хангах /мотоцикл/ ажлыг 59950000 (тавин есөн сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр Багахөгшин ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол) нарт даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 4 дүгээр багц Сумдын Эрүүл мэндийн төвийг гал тогооны тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100676

D:My Doc. Zahiramj. Zasag darga